



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№124 /338/

2022.07.18

Цаг үе, үйл явдал

ДОЛОО ДАХЬ УДААГИЙН ТӨГСӨЛТ БОЛЛОО



Батлах хамгаалахын сайдын "Цэргийн мэргэжлийн боловсрол, шаталсан сургалтын тогтолцоо батлах тухай", "Үндэсний батлан хамгаалахын их сургуульд 2021-2022 онд элсэлт авах мэргэжил, хяналтын тоо батлах тухай" тушаалыг тус тус үндэслэн "Салааны захирагчийн орлогчийн дамжаа"-г Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-

үйлдвэрлэлийн төвийг түшиглэн 4 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн 3 сарын хугацаатай зохион байгууллаа. Долоо дахь удаагаа хичээллэсэн уг дамжаанд Зэвсэгт хүчний 31 нэгтгэл, анги, салбарын 50 гаруй ахлагч хамрагдан амжилттай суралцаж төгсөв.

Сургалтын хугацаанд сурлага, мэдлэг, ур чадвараараа бусдыгаа манлайлан суралцсан

суралцагчдаар дараах алба хаагчид шалгарсан юм. Тодруулбал, "Шилдэг тамирчин" төгсөгчөөр ахлагч З.Батхуяг, "Шилдэг жагсаалч" төгсөгчөөр ахлах ахлагч Б.Батзориг, "Шилдэг суралцагч"-аар ахлах ахлагч Б.Давадалай, "Шилдэг илтгэгч"-ээр ахлах ахлагч Ч.Баттулга, "Шилдэгийн шилдэг" төгсөгчөөр ахлах ахлагч Ц.Баатарбилэг нар шалгарав. Төгсөлтийн арга

хэмжээнд ҮБХИС-ийн зарим удирдлага, ЗХЖШ-ын ахлагч, тэргүүн ахлагч Н.Баасан болон төрлийн цэргийн командлалуудын тэргүүн ахлагч нар оролцсон юм.

"ТӨРИЙН ДАЛБААНЫ ӨДӨР"- ИЙГ ЁСЛОЛ ТӨГӨЛДӨР ТЭМДЭГЛЭЛЭЭ



БНӨСУ-д энхийг сахиулах үүргээ нэр төртэй гүйцэтгэж байгаа мотобудлагын батальоны бие бүрэлдэхүүн "Төрийн далбааны өдөр"-ийг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлээ. Тус арга хэмжээнд мотобудлагын батальоны бие бүрэлдэхүүн мөн штабын холбогч офицерууд оролцов.

Арга хэмжээг нээж мотобудлагын батальоны захирагч хурандаа О.Заяат

нийт бие бүрэлдэхүүнд хандан мэндчилгээ дэвшүүлж, албан тушаалын зэрэглэлийн дагуу цэргийн цол хүртсэн алба хаагчдын цолыг гардуулж өгсөн юм. Түүнчлэн "Төрийн далбааны өдөр"-өөр Монгол Улсад зохион байгуулагдсан Цэргийн ёслолын жагсаалыг бие бүрэлдэхүүнд үзүүлээ.

Ахлах дэслэгч П.БАЯЛАГМАА

АТГ-аас мэдээлж байна

ХАГАС ЖИЛИЙН ХУГАЦААНД ХОЁР ИХ НАЯД ГАРУЙ ТӨГРӨГИЙН ХОХИРОЛ УЧИРСАН

Батлан хамгаалах яам, Авлигатай тэмцэх газрын хамтын ажиллагааны хүрээнд авлигын эсрэг үйл ажиллагааг зэрэглэлийн дагуу цэргийн цол хүртсэн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, ажилтан, албан хаагчдад Авлигын эсрэг мэдээ, мэдээллийн цаг алдалгүй шуурхай хүргэх ажлыг зохион байгуулж, хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд "Соёмбо мэдээ" сонинд Авлигатай тэмцэх газрын мэдээлэл буланг сар бүр явуулахаар төлөвлөсөн билээ.

Тус ажлын хүрээнд цэргийн алба хаагчдад авлигын эсрэг мэдээ, мэдээллийн цаг алдалгүй шуурхай хүргэх ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна.

Уг ажил нь цэргийн алба хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг хангах, тэдний оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах, шударга ёсны үзэл санааг олон нийтэд төлөвшүүлэн, соён гэгээрүүлэх, тэдний идэвх санаачилгыг өрнүүлэх, идэвхжүүлэх, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх үр дүнтэй юм.

Манай байгууллага 2022 оны эхний хагас жилд шалгагдсан гэмт хэргийн улмаас 2,061,324,104,812.00 / хоёр их наяд, жаран нэгэн тэрбум, гурван зуун хорин дөрвөн сая, нэг зуун дөрвөн мянга, найман зуун арван хоёр / төгрөгийн хохирол учирсан

-Мөрдөн шалгах ажиллагааны явцад 1,235,701,691,027.44 /нэг их наяд

хоёр зуун гучин таван тэрбум, долоон зуун нэг сая, зургаан зуун ерэн нэгэн мянга, хорин долоо / төгрөгийн хохирлыг буюу 60.0 хувийг нөхөн төлүүлсэн

-Үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 382,746,448,140.00 /гурван зуун наян хоёр тэрбум, долоон зуун дөчин зургаан сая, дөрвөн зуун дөчин найман мянга, нэг зуун дөч / төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

Хэргийн мөрдөн шалгах ажиллагааны явцад Хөгжлийн банктай хамтран зээлийн эргэн төлөлтөд 269 тэрбум 540 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлээд байна.

Хахуулийн 4,037,934,407.00 / дөрвөн тэрбум гучин долоон сая есөн зуун гучин дөрвөн мянга, дөрвөн зуун долоон мянга / төгрөгийг хураан авч, улсын орлого болгосон.

Үүнийг өмнөх мөн үетэй харьцуулбал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэлт 2.1 дахин, хохирол нөхөн төлүүлэлт 13.9 дахин, битүүмжлэн хамгаалсан хөрөнгө 3.4 дахин өссөн үзүүлэлттэй байна.

АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Н.БАТЧУЛУУН

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 27	🌧️ 16


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 29	🌧️ 22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.165.00	3.175.0
EUR 🇪🇺	3.175.0	3.250.0
CNY 🇨🇳	470.00	475.00
RUB 🇷🇺	51.00	52.00
JPY 🇯🇵	22.60	23.40
KRW 🇰🇷	2.38	2.42

ЗУРХАЙ



2022.07.17 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 21

ЗУНЫ ДУНД УЛААН МОРЬ САРЫН НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ТАХИА ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.13-20.44

Барилдлага:

Үхэх

Шүтэн барилдлага:

Мунхрахуй

Суудал: Уул

Энэ өдөр үхэр, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, хагалгаа хийлгэх, буг дарах, газрын ам бооход сайн. Мод суулгах, нарийн чанд зөвлөгөөн хийх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогосод баруун хойд зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 567,857,190

Эдгэрсэн

Нийт: 539,000,442

Нас барсан

Нийт: 6,387,812

Цахим шууданд

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН ДУНД "БЭСРЭГ НААДАМ" ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний 110 дугаар анги

Энэ сарын 13-ны өдөр хугацаат цэргийн алба хаагчдын дунд зохион байгуулсан "Бэсрэг наадам"-аар 48 бөх зодоглосон бөгөөд Булган аймгийн Гурванбулаг сумын харьяат байлдагч Б.Бямбадорж түрүүлэн мөн сумын харьяат ахлах байлдагч М.Сандагдорж үзүүлэв.

Багийн шагайн харваагаар 6 баг өрсөлдсөнөөс Булган аймгийн Гурванбулаг сумын харьяат байлдагч

Г.Дэлгэрбаяр ахлагчтай баг бусдыгаа манлайлан түрүүлээ. Наадмын үеэр дэд түрүүч Д.Бадамдорж, байлдагч Г.Бат-Оргил нар ая дууны мэндчилгээ дэвшүүлэв.

Ахмад Т.МӨНХ-ЭРДЭНЭ

Б.МӨНХЦЭЦЭГ АЙМГИЙН МЭРГЭН ЦОЛ ХҮРТЭВ



Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Тулгар төрийн 2231, Их Монгол Улс байгуулагдсаны 816, Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, Баян-Өлгий аймгийн Үндэсний их баяр наадмын "Үндэсний сурын харваа"-нд тус

ангийн Холбооны албаны техник хэрэгслийн инженер Б.Мөнхцэцэг оролцож 40 сумнаас 40 харваж түрүүлэн "Аймгийн мэргэн" цол хүртлээ. Мөн "Аймгийн гарамгай" харваач ажиллагааны ахлагч, ахлах ахлагч Э.Цогтбаяр 40 сумнаас 30 харваж гутгаар байрт шалгарч анги, хамт

олныхоо нэрийг өндөрт өргөж, нутгийн зон олноо цэнгүүлсэн сайхан амжилтыг үзүүлээ. Эрхий мэргэн харваачдын хараа нь хурц, сум нь мэргэн байж ирэх жилийн наадмаар "Улсын мэргэн" болох болтугай.

Ахлах дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН

ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙНХЭН НЭГДСЭН ТООЛЛОГО ЯВУУЛЖ, МОНГОЛ УЛСЫН ЦЭРГИЙН ТАНГАРАГАА ДАВТЛАА



Зэвсэгт хүчний 014 дүгээр анги

Тулгар төрийн 2231, Их Монгол Улсын 816, Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан энэ сарын 8-ны өдөр Монгол Улсын цэргийн тангараг давтаж, нэгдсэн тооллого явууллаа. Энэ үеэр Хуурай Замын цэргийн командлагч болон ангийн захирагчийн тушаалаар

зарим цэргийн алба хаагчдад хугацааны цол олгов. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Ардын хувьсгалын 100 жилийн ойн медаль, Батлан хамгаалахын сайдын тушаалаар "Дайчин алдар" медаль болон "Эх орны төлөө" хүндэт тэмдгээр шагнагдсан алба хаагчдын шагналыг ангийн удирдлага гардуулж өглөө.

Түнчлэн сахилга, сурлага, ажил албаараа бусдыгаа манлайлан цэргийн

алба хаагчид, ажилтан албан хаагчдад ангийн захирагчийн тушаалаар "Ангийн байлдааны дэлгээ тугийн дэргэд авхуулсан зураг", "Талархлын захидал"-аар сайшаал хүртээв. Арга хэмжээний төгсгөлд ангийн захирагч хурандаа Г.Эрдэнэбаатар бие бүрэлдэхүүнд Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойн баярын мэндчилгээ дэвшүүлсэн юм.

Дэслэгч Р.Билэг

ТӨРИЙН ТОРГОН ЦЭРГҮҮД ЦЭРГИЙН ГЭРЭЭТ АЛБА ХААГЧААР ЭГНЭЭГЭЭ ТЭЛЭВ



Зэвсэгт хүчний 032 дугаар анги

Тус анги 2021 онд хугацаат цэргийн албанд татагдсан дайчдыг бэлтгэлээр халах, Байлдааны туганд хүндэтгэл үзүүлэх ажиллагааг зохион байгууллаа. Бид бүхний сүсэглэн дээдлэх оройн дээд шүтээн, цог хийморийн бэлгэдэл аранзал улаан тугаа залснаар үйл ажиллагаа эхэлсэн юм. Бие бүрэлдэхүүнд 2021 онд хугацаат цэргийн албанд татагдан ирсэн 10 алба хаагчийг бэлтгэлээр халах

тухай ЗХЖШ-ын даргын болон ангийн захирагчийн тушаалыг уншиж танилцуулан, Байлдааны туганд хүндэтгэл үзүүлж, сүүн цацал өргөн, цэргийн гэрээт албаны түрүүч, байлдагчийн гэрээг гардуулж, 10 хоногийн цалинтай чөлөөгөөр шагналаа.

Ангийн захирагч хурандаа М.Болдбаатар арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ хүндэт харуулын ангид анхны цэргийн гэрээт алба хаагчдаар томилогдож, төрийн торгон цэргийн түүхэнд нэгэн шинэ хуудас

нээснийг дурдаад дайчдад баяр хүргэн, цаашдын ажилд нь амжилт, амьдралд нь сайн сайхан бүхний дээдийг ерөөлөө.

Эх орноо батлан хамгаалах, төрийн болон цэргийн ёслол хүндэтгэлийн хариуцлагатай үүргээ үлгэр жишээчээр гүйцэтгэж, цэргийн гэрээт албанд томилогдсон түрүүч, байлдагчдыг төлөөлж, харуул үйлчилгээний тусгай ротын дэд түрүүч Б.Батдэлгэр мөн үг хэлсэн юм.

Ахмад О.ГЭРЭЛЗАЯА

ДУУ ХУУРТАЙ, ХУР БОРООТОЙ САЙХАН НААДЛАА

Зэвсэгт хүчний 350 дугаар анги

Ардын хувьсгалын 100, 101 жил, анги үүсэн байгуулагдсаны 11 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан "Шагайн наадгай" (Морь уралдуулах)-н тэмцээнд нягтлан Б.Хонгорзул, дэд хурандаа С.Мөнхжаргал, ахлагч н.Түмэнжаргал, н.Пүрэвням,

Б.Наяжав нар эхний байруудад шалгарлаа. Мөн "Дэмбээ"-ний тэмцээний тэргүүн байрт дэд хурандаа Б.Ууганбаяр, дэд байрт ахлагч А.Батбаяр, гутгаар байрт Ө.Ханд, "Шагайн харваа"-ны тэмцээний тэргүүн байрт ахмад Б.Дэрдэнэниж, дэд байрт ахлах ахлагч Ө.Түвшинжаргал, гутгаар байрт тэргүүн ахлагч Т.Сандагдорж ахлагчтай багууд шалгарав. Тэгвэл хүчит 32

бөхийн барилдаанд ахлагч Б.Далайсайхан түрүүлж, ахлагч Б.Жавхалантөгс үзүүрлэсэн бөгөөд ахлах ахлагч Д.Чулуунбаатар, Ц.Мөнх-Эрдэнэ нар шөвгөрч, ахлах ахлагч Б.Борбил "Уран барилдаанч бөх"-өөр нар шалгарлаа.

Ахмад Б.ДЭРДЭНЭНИЖ